



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/35

Мандалговь

Багийн эмчийн үзлэгийн багцын тоног
төхөөрөмж хуваарилах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн “Багийн эмчийн үзлэгийн багцын тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийг орлогод авч, хуваарилах, үндсэн хөрөнгөд бүртгэх туха” А/215 дугаар тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын буцалтгүй тусламжаар багийн эмч нарын ажиллах нөхцлийг сайжруулах хүрээнд нийлүүлэгдсэн 53,564,028 (тавин гурван сая таван зуун жаран дөрвөн мянга хорин найман) төгрөгийн үнэ бүхий 11 нэр төрлийн багийн эмчийн үзлэгийн багцын тоног төхөөрөмжийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох журам, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэн хөрөнгийн бүртгэлд авч, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг холбогдох Эрүүл мэндийн төвүүдийн дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Ц.Энхсайхан)-т даалгасугай.

ДАРГА  Б.АЛТАНТӨГС



